

Австрали Монголын Эрдэс баялгийн  
салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр  
(АМЕП 2)

Жилийн ажлын тайлан 2019/20

2020 оны 8 дугаар сар

# Агуулга

|                                                                                                                         |    |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| Агуулга .....                                                                                                           | 2  |
| Товчилсон үгс.....                                                                                                      | 3  |
| Гүйцэтгэлийн хураангуй.....                                                                                             | 4  |
| Хөтөлбөрийн зорилтууд, явц .....                                                                                        | 6  |
| Олон нийтийн харилцааны стратеги, хэрэгжилт .....                                                                       | 8  |
| “Хамтын ажиллагааны талаарх талуудын үзэл бодол, хандлага” судалгаа .....                                               | 8  |
| Үйл ажиллагааны хураангуй.....                                                                                          | 10 |
| Төсөл 1. Монгол Улсын ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний кодекс боловсруулах (МОНВАЛ) .....                           | 10 |
| Төсөл 2. Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, хүлээн авах журмыг шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх .....               | 11 |
| Төсөл 3. МУ-ын геологийн мэдээллийн каталог системд мэдээллийг бүрэн оруулах нь. 11                                     |    |
| Төсөл 4. Монгол дахь уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн үеийн нягтлан бодох бүртгэлийн аргачлал боловсруулах нь..... | 12 |
| Судалгааны төсөл 1. Нүүрсний давхаргын метан хий (НДМХ) – Австралийн эрх зүйн орчин, зохицуулалт.....                   | 12 |
| Хавсралт 1: Өөрчлөлтийн онол .....                                                                                      | 14 |

# Товчилсон үгс

|                 |                                                                                        |
|-----------------|----------------------------------------------------------------------------------------|
| АМЕП            | Австрали – Монголын Эрдэс Баялгийн Салбарын Хамтын Ажиллагааны Хөтөлбөр (1 дүгээр шат) |
| АМЕП 2          | Австрали – Монголын Эрдэс Баялгийн Салбарын Хамтын Ажиллагааны Хөтөлбөр 2 дугаар шат   |
| АСИ             | Адам Смит Интернэйшнл                                                                  |
| НДМХ            | Нүүрсний давхаргын метан хий                                                           |
| ГХХЯ            | Гадаад хэрэг, худалдааны яам                                                           |
| ОУИТБС          | Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга                                       |
| СҮААХ (FATF)    | Санхүүгийн үйл ажиллагааны ажлын хэсэг (ФАТФ)                                          |
| СЗХ             | Санхүүгийн зохицуулах хороо                                                            |
| УУХҮЯ           | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам                                                        |
| АМГТГ           | Ашигт малтмал, газрын тосны газар                                                      |
| ХШҮ             | Хяналт-шинжилгээ ба үнэлгээ                                                            |
| ТББ             | Төрийн бус байгууллага                                                                 |
| ЭЗХАХБ          | Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага                                   |
| ТХН             | Төсөл хэрэгжүүлэх нэгж                                                                 |
| БДХХС (PSEAN)   | Бэлгийн дарамт, хүчирхийлэл, халдлагаас сэргийлэх                                      |
| ЭУМ             | Эрсдэлийн удирдлагын матриц                                                            |
| СЕСМИМ (SESMIM) | Монгол улсын эрдэс баялгийн салбарын удирдлагыг бэхжүүлэх төсөл                        |

# Гүйцэтгэлийн хураангуй

Өнгөрсөн нэг жилийн хугацаанд АМЕП 2 хөтөлбөр нь төлөвлөсөн төсөл, ажлуудаа амжилттай хэрэгжүүлж, илүү өргөн хүрээнд хамтын ажиллагаагаа бэхжүүлж, ирэх жилүүдийн амжилт, бүтээлийн сууриа тавилаа. АМЕП 2 хөтөлбөрийн эхний жилийн үйл ажиллагаа үндсэн хоёр үе шатаас бүрдэнэ. Эхний шатанд хөтөлбөрийн баг нь хөтөлбөрийн өмнөө тавьсан зорилгод хувь нэмэр оруулах, нөлөөллийн түвшинд ажиллах чадвар чадавхитай түншлэгч талуудтай хамтын ажиллагаа эхлүүллээ. Дараагийн шатанд Австралийн Гадаад хэрэг, худалдааны яам (ГХХЯ) болон Монгол Улсын Сангийн Яамны баталсан зургаан төслийн хэрэгжилтийн үйл явцуудыг АМЕП 2 багтааж байна. Төсөл тус бүрийг шийдвэр гаргах түвшний байгууллага, Засгийн газрын агентлаг хариуцан хэрэгжүүлээ. УУХҮЯ, АМГТГ, СЯ, СЗХ зэрэг төрийн байгууллагатай эхлүүлсэн хамтын ажиллагаа нь эрх зүйн зохицуулалтыг хүлээн зөвшөөрөх, улмаар тогтвортой дагаж мөрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

*АМЕП 2 хөтөлбөр нь төр, иргэний нийгэм, хувийн хэвшилтэй хамтран ажиллах замаар Монгол Улсын эрдэс баялгийн салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах зорилготой.*

АМЕП 2 эхний жилийн төлөвлөгөөнд тусгасан ажлуудаа хэрхэн гүйцэтгэсэн болон зургаан төслийн хэрэгжилтийг энд тайлагналаа. Улмаар энэхүү тайлан нь АМЕП 2 хөтөлбөрийн өмнөө тавьсан зорилготой жил бүрийн сонгон хэрэгжүүлж буй төсөл, тэдгээрийн үр дүн хэрхэн уялдаж байгааг Австралийн ГХХЯ-нд илтгэх зорилготой юм. 2019-өөс 2020 онд хэрэгжүүлсэн зургаан төслөөрөө дамжуулан, АМЕП 2 хөтөлбөр ил тод, шударга, урьдчилан таамаглах боломжтой хөрөнгө оруулалтын орчин бий болгоход хувь нэмрээ орууллаа. Үүнийг дэлгэрүүлбэл:

- Төр болон хувьцаа эзэмшигчдэд ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний талаарх үнэн, зөв мэдээллийг компани өгөх шаардлагатай байдаг. Тиймээс ашигт малтмалын хөрөнгийг хэрхэн үнэлэх зөвлөмжийг олон улсын туршлага, хөрөнгийн үнэлгээний кодоод суурилан боловсууллаа.
- СЯ-тай хамтран ажиллаж, уул уурхайн салбарын нягтлан бодох бүртгэлийн дүрэм журмын хэрэгжилтийг сайжруулах замаар уурхайн хаалт болон нөхөн сэргээлтэд шаардлагатай хөрөнгө санхүүг компаниуд тусгаж байхаар тогтлоо.

Уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийг стандартын дагуу, чанартай хийх, боловсруулсан үндэслэлийг хүлээн авч, түргэн шуурхай батлах нөхцөл орчинг бүрдүүлэх зорилгоор АМЕП 2 олон оролцогч талыг нэгтгэн ажиллалаа. Энэ нь уул уурхайн салбарт тодорхой, бүхий л тал хүлээн зөвшөөрсөн дүрэм журам бий болгоход хувь нэмрээ оруулж буй хэрэг юм. Мөн МонГеоКат геологийн мэдээллийн санд мэдээлэл оруулах ажлыг санхүүжүүлэв. Монгол Улсын Засгийн газрын хөрөнгө оруулагч татах, илүү сайн үйлчилгээ үзүүлэх зорилго зорилтод МонГеоКат төсөл чухал ач холбогдолтой. Түүнчлэн, хөтөлбөрийн хүрээнд Австралийн нүүрсний давхаргын метан хийн эрх зүйн орчин, институцийг судалж, Монгол Улс нөхцөл, онцлогтоо тохируулан, аль хэсгийг авч хэрэгжүүлж болох талаар зөвлөмж гаргалаа. Энэ нь МУ мэдээлэл судалгаа, нотолгоонд суурилсан шийдвэр гаргахад хувь нэмэр оруулж буй хэрэг юм.

Дээр дурьдсан зургаан төслийн хүрээнд хамтран ажиллаж буй Монгол Улсын төрийн байгууллагын ажилтан, шийдвэр гаргагчдад олон улсын туршлагын талаарх мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж, төр, хувийн хэвшил, мэргэжлийн холбоодын хамтын ажиллагааг дэмжин ажиллалаа.

АМЕП 2-ын сонгон шалгаруулсан төсөл бүр хэрэгжүүлэгч эзэнтэй. Эдгээр төсөл хэрэгжүүлэгчийнхээ зорилго зорилт, ажлын орчин нөхцлийг АМЕП 2 ойлгон, дэмжиж ажиллахыг чухалчилсаар ирлээ. Зургаан төслийн хэрэгжүүлэгч нар дараах үр дүнг гаргахаар ажиллаж байна. Үүнд:

- Монгол Улс олон улсын тэргүүн туршлагад нийцүүлэн, өөрийн гэсэн ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний кодтой (МОНВАЛ) болж, хэрэглэж эхэлнэ. Хөрөнгийн үнэлгээний код нь Засгийн газар, хувийн хэвшил хоорондын зөвшилцөл хийх үйл явцыг хялбар дөхөм болгодог.
- ТЭЗҮ-тэй холбоотой дүрэм журмыг шинэчлэн баталж, хэрэгжүүлж эхэлснээр ТЭЗҮ батлах үйл явцыг илүү үр дүнтэй болгоно.
- МонГеоКат системийн мэдээллийг бүрэн оруулж дуусгалаа. Ингэснээр цахим хэрэглэгч мета-датад нэвтрэх боломж бүрдлээ.
- Нүүрсний давхаргын метан хийн болон бусад ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайн давхцалтай холбоотой Австрали, Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгааг хийж гүйцэтгэлээ.

- Монгол Улс дахь уурхайн хаалт болон нөхөн сэргээлттэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн стандартыг хэрхэн ашиглах удирдамж боловсрууллаа.

Төсөл хэрэгжүүлэгчид зайлшгүй шаардлагатай ажилд мөнгө зарцуулж, арвич хямгач зарчмыг мөрдлөг болгож ажиллалаа. АМЕП 2 “Төсөл хөтөлбөр сонгон шалгаруулах, хэрэгжүүлэх удирдамж”-ид заасан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу зургаан төслөө сонгосон. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудын дунд явуулсан судалгаагаар тэдний хамтрагч байгууллагууд болох засгийн газрын агентлагууд төслийн хүрээнд хийгдсэн ажлууд хэрэгцээ шаардлагыг олж мэдэрсэн, зөв зүйтэй ажил байсан хэмээн үнэлжээ. АМЕП 2 хөтөлбөрийн баг төслүүдээ үр дүнтэй хэрэгжүүлэх арга замаа олж авсан бөгөөд тавьсан зорилгодоо хүрэхэд алхам алхмаар дөхөж байна гэж үзэж байна. Хөтөлбөрийн газраас хэрэгжүүлж буй төсөл, ажлуудын үр шимийг салбарын мэргэжилтнүүд эхнээсээ ойлгон үнэлж, нөгөөтэйгүүр хөтөлбөрийн баг оролцогч талуудтай илүү нягт хамтран ажиллаж буй нь төслүүд амжилттай хэрэгжихэд илүү их тус дэм болно хэмээн найдаж байна.

АМЕП 2 хөтөлбөр өнгөрсөн хугацаанд үндсэн харилцагч талуудтай ил тод, идэвхитэй харилцах зарчим бүхий Олон нийттэй харилцааны стратегиэ мөрдөж ажиллалаа. Үндсэн оролцогч талуудыг цаг үеийн мэдээллээр хангах, тэдэнтэй биечлэн уулзахыг чухалчиллаа. Мөн уул уурхайн салбарын хурал уулзалт, сар тутмын мэдээллийн хуудас, хөтөлбөрийн цахим хуудас, фейсбүүк, твиттерээр дамжуулан, хөтөлбөрийн талаарх мэдээллийг олон нийтэд цаг тухайд нь хүргэж байна. АМЕП 2 сар тутмын мэдээллийн хуудсыг цахим хэлбэрээр Монгол Улсын ЗГ, олон улсын хөгжлийн байгууллагууд, мэргэжлийн холбоод, салбарын төлөөлөл болон иргэний нийгмийн байгууллагуудад илгээж байна. Хөтөлбөрийн хүрээнд бэлтгэн гаргасан тайлан, судалгаа, олон улсын тэргүүн туршлагыг бүрэн эхээр нь олон нийтэд түгээх үндсэн суваг нь АМЕП 2 хөтөлбөрийн цахим хуудас юм. Олон нийтийн хамгийн түгээмэл хэрэглэдэг фейсбүүк, твиттерт зэрэг нийгмийн сүлжээнд АМЕП 2 өөрийн данс, хуудас нээн ажиллуулж байна. Эдгээр сошиал хуудсуудад АМЕП 2 цахим хуудсанд нийтэлсэн мэдээллүүдээ богино хэлбэрээр тавьж, уул уурхайн мэдээллийг илүү олон хүнд, хүртээмжтэйгээр хүргэж байна. Хөтөлбөрийн нэгдүгээр үе шаттай харьцуулахад эдгээр мэдээллийн сувгийг нээн, олон нийттэй шууд харилцаж, эргэх холбоо үүсгэн ажиллаж байгаа нь АМЕП 2-ын хувьд томоохон алхам байлаа. Олон нийтийн хандалт, сонирхон тавьж буй асуултуудаас дээрх сувгуудыг нээсэн нь оновчтой шийдвэр байсан нь харагдаж байна.

АМЕП 2 хоёр дахь жилдээ хөтөлбөрийн зорилгод хувь нэмрээ оруулан, хамтран ажиллах байгууллага, мэргэжлийн холбоодын тоог нэмэх боломж бололцоог үргэлжлүүлэн хайж байна. Эхний жилийн үйл ажиллагаанаас авсан сургамжийн нэг нь төслийн үзэл баримтлал боловсруулах, оролцогч талуудтай зөвлөлдөх хугацааг хангалттай тавьж өгөх байсан болно. Зөвлөлдөх үйл явцыг яаравчлахгүй байх нь тухайн жилийн ажлын төлөвлөгөөнд тусгах бодлогын асуудлыг ул суурьтай ойлгон судлах, хамтрагч талуудтай анхнаас нь санал солилцох боломжийг олгох болно.

# Хөтөлбөрийн зорилтууд, явц

Өөрчлөлтийн онолд зааснаар төсөл хөтөлбөрүүд оролцогч талуудтай хамтран хэрэгжүүлж буй ажлуудаараа дамжуулан, тавьсан зорилтуудаа биелүүлсээр эцсийн бүлэгт томоохон өөрчлөлтийг хийж чаддаг байна (Хавсралт 1). Зан төлвөө өөрчлөх сэдлийг шийдвэр гаргагч болон хамтрагчдадаа төрүүлэх, тэдний зан төлөвт өөрчлөлт гаргахыг хичээн ажиллана. АМЕП 2 хөтөлбөр 2023 он хүртэл хэрэгжих бөгөөд энэ хугацаанд гүйцэтгэх бүх ажлаа хоёр үндсэн чиглэлд ангилсан. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах зорилготой ажиллаж буй оролцогч талуудад мэргэжлийн өндөр түвшний техникийн туслалцаа үзүүлэх;
- Уул уурхайн салбарт чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудыг санал солилцон, зөвшилцөн ажиллахад нь дэмжлэг үзүүлэх тэгш, хүртээмжтэй түншлэл бий болгох замаар Монгол Улсын эрдэс баялгийн салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж чадна.

Хамтран ажиллахын ашиг тусыг харах өнцөг, зан үйлийг өөрчлөхөөс гадна АМЕП 2 хөтөлбөр түншүүдтэйгээ хамтран хэрэгжүүлж байгаа төсөл, үйл ажиллагаагаараа дамжуулан бодит үр дүн гарган ажиллахыг зорьж байна. Үүнд эрдэм шинжилгээний судалгаа хийх, техникийн туслалцаа үзүүлэхээс гадна, үр дүнтэй түншлэл үүсгэхийн тулд олон талыг хооронд нь холбож өгөх, яриа хэлэлцээ зохион байгуулах ажлууд багтана.

АМЕП 2 эхний жилийн тайландаа багтаах зорилгоор оролцогч талуудаасаа хамтын ажиллагааны талаар ямар санаа бодолтой байгааг нь анх удаа асууж, судалгаа хийсэн. 2019 оны сүүлээр хийсэн “Хамтын ажиллагааны талаарх үзэл бодол, хандлага” судалгааны товчийг энэ тайланд оруулсан байгаа. Мөн АМЕП 2 хөтөлбөрийн үйл ажиллагааны чанар, уриалгахан байдлыг үнэлэх тогтолцоог тайландаа тусгалаа.

АМЕП 2 төслийн үйл ажиллагаа 2019 оны 4 дүгээр сард эхэлж, хэрэгжүүлэх хөтөлбөрүүдээ сонгон шалгаруулсан. Улмаар хоёр улсын Засгийн газар зургаан төсөл баталж, төслүүдийн үйл ажиллагаа 2019 оны 10 дугаар сард эхэлжээ. Төсөл бүрийг түншлэгч талууд тэргүүлэн удирдаж ажилладаг. Тиймээс АМЕП 2 хамтрагч бүрийнхээ хариуцдаг төслийн төлөвлөгөө, зорилго, үр дүнг нухацтай судалж, дэмжин ажиллалаа. Тооцоолж байсанчлан зургаан төслийн хэрэгжилт, гаргасан үр дүн өөр өөр түвшинд байна.

- АМЕП 1 хөтөлбөрийн хүрсэн үр дүн, олонд танигдсан амжилтад үндэслэн, АМЕП 2 эхний жилдээ илүү олон түнш, оролцогч талтай харилцаа холбоо тогтоож, улам далайцтай үйл ажиллагаа явуулахыг зорилоо.
- Хөтөлбөрийн загварчлалтай уялдуулан эхний жилийн төслүүдээ сонгож, яамд, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллалаа. Хөтөлбөрийн эхний шатанд ажиллаж байсан бодлогын асуудлуудыг үргэлжлүүлсний зэрэгцээ шинэ сэдвүүдийг хөндсөн төсөл, үйл ажиллагааг АМЕП 2 хамтрагч нартайгаа хэрэгжүүллээ.
- Төслийн хэрэгжилт, шат бүрт оролцогч талуудыг татан оролцуулах, хамтран ажиллах бүхий л боломжийг АМЕП 2 эрэлхийлж ажилласан. Одоогийн байдлаар АМЕП 2 хөтөлбөрийн дэмжлэггүйгээр, бие даан хамтын ажиллагаа эхлүүлсэн тохиолдол гараагүй байна. Оролцогч талууд хоорондоо хамтран ажиллах санал санаачлага гарахад тодорхой хугацаа шаардагдахаар байна.
- АМЕП 2 хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй төслүүд нь “Хөтөлбөрийн загварчлал” баримт бичигт заасан хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад дараах чиглэлээр хувь нэмэр оруулж байна. Үүнд:
  - Дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор хөрөнгө оруулалтын орчныг ил тод, нээлттэй, шударга, тогтвортой болгож байна. Үүнд МОНВАЛ хөрөнгийн үнэлгээний кодекс, нягтлан бодох бүртгэлийн стандартууд багтана.
  - Уул уурхайн салбар хариуцсан төрийн байгууллагын үйлчилгээг сайжруулах чиглэлд МонГеоКат геологийн мэдээллийн цахим сан ашиг тусаа өгч байна.
  - Эрдэм шинжилгээний судалгаа, баримтад тулгуурласан олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх хүрээнд нүүрсний давхаргын метан хийн харьцуулсан судалгаа хийж гүйцэтгэлээ.
  - Нийтээр хүлээн зөвшөөрсөн дүрэм журам боловсруулах чиглэлд уурхайн техник, эдийн засгийн үндэслэл хэрхэн хийх, батлах, хүлээн авах талаар ажиллалаа.
  - Бүх төсөл дэлхийн тэргүүн туршлага, олон талын харьцуулалт, судалгаанд үндэслэж байна.
- 2020 оны сонгуулийн дараа улс төрийн орчин тогтвортой байна гэж дүгнэж болохоор байна. Харин эдийн засаг хүндрэх магадлалтай тул АМЕП 2 үйл ажиллагаагаа хэвийн явуулах орон зай гэдэгт ямар нөхцлийг авч үзэхээ дахин тодорхойлж, эдийн засгийн хүндрэлийг бодолцсон, гэхдээ илүү үр өгөөжтэй төслүүд бүхий ажлын төлөвлөгөө боловсруулах шаардлагатай.

# Олон нийтийн харилцааны стратеги, хэрэгжилт

АМЕП 2 төслийн мэдээллээ олон нийтэд тогтмол, идэвхтэй түгээх харилцааны зарчмаа мөрдлөг болгон ажиллалаа. Энэ зарчим нь “Тэгш, хүртээмжтэй оролцоог хангах нь” судалгааны үр дүнд үндэслэсэн бөгөөд төслийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг Монгол, Англи хэл дээр тодорхой, хүртээмжтэй хүргэх зөвлөмжийг мөрдлөг болгосон. Олон нийттэй нүүр тулан уулзах, төсөл хөтөлбөрүүдээ танилцуулахад Багийн ахлагч манлайлан оролцож, Дисковер Монголиа хөрөнгө оруулагчдын чуулган (2019 оны 9 дүгээр сар), Монголын бизнесийн зөвлөлийн хурал (10 дугаар сар), УБ дахь Австралийн худалдааны танхимын уулзалт, Эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр зэрэг арга хэмжээнд (12 дугаар сар) илтгэл тавилаа.

АМЕП 2 хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар мэдээллийн хуудас бэлтгэн, оролцогч тал, түншүүддээ цаг тухайд нь хүргэж байна. 2020 оны 3 дугаар сарын байдлаар АМЕП 2 хөтөлбөрийн мэдээллийн хуудсын гурван дугаарыг Монгол, Англи хэл дээр бэлтгэн, Засгийн газар, олон улсын хөгжлийн байгууллага, түнш, мэргэжлийн холбоод, компани, иргэний нийгмийн байгууллагуудад цахимаар хүргүүлээ. Эдгээр мэдээллийн хуудсаар дамжуулан, Монвал, МонГеоКат, ТЭЗҮ төслүүдийг дэлгэрэнгүй танилцуулсан. Эдгээр мэдээллийн хуудсыг 400 орчим хэрэглэгч нээн уншжээ.

2020 оны 1 дүгээр сард хөтөлбөрийн цахим хуудсыг (amer.mn) нээж, Монгол, Англи хэл дээр ажиллуулж эхэллээ. АМЕП 2 хөтөлбөр вэбсайт хөгжүүлэгчээрээ дотоодын компани сонгон шалгаруулж, олон нийтийн сүлжээний сувгуудтай холбогдсон цахим хуудсаа хөтөлбөрийн бүхий л үйл ажиллагаа, мэдээлэл түгээх үндсэн суваг болгон ашиглаж байна. Цахим хуудсын “Мэдээ мэдээлэл” дэд цэст АМЕП 2 хөтөлбөрийн хүрээнд бэлтгэсэн бүх тайлан, судалгаа, олон улсын туршлага, харьцуулалт, илтгэл нийтлэлийг тухай бүрт нь тавьж, олон нийт хүссэн үедээ татаж авах, хэрэглэх боломжоор хангалаа. Цахим хуудаст хоёр долоо хоног тутамд шинэ мэдээ мэдээлэл, судалгаа оруулж, тэдгээрийг нийгмийн сүлжээгээр идэвхтэй түгээж байна.

Мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор фэйсбүүк болон твиттер сувгууд дээр АМЕП 2 өөрийн хуудас, данс нээн ажиллуулж байна. 2019-2020 онд АМЕП 2 нийт 276 удаа мэдээлэл оруулж, 70 мянган хандалт (engagement) авсан. Эдгээр хандалтад мэдээний дор бичсэн сэтгэгдэл, бусдад түгээв, таалагдлаа (comment, share, like) гэх мэт тэмдэглэгээ дарсан үйлдлүүд багтана. Зорилтот бүлгийн сонирхлыг татах үүднээс нийгмийн сүлжээнд тавих мэдээ бүрээ зураг, цахим хуудас руу хандах холбоостой хийнэ гэсэн зорилтоо биелүүлж ажиллалаа. Хөтөлбөрийн Фэйсбүүк хуудсанд 600 гаруй хүн нэгдэж, (298 лайк, 316 дагагч) АМЕП-ийн мэдээллийг тогтмол авч байна. Агуулгын төлөвлөгөөний дагуу сар бүр нэг төслийг онцлон танилцуулдаг. Жишээ нь 2019 оны 10 дугаар сарыг МонГеоКат геологийн каталог систем, ач холбогдлыг танилцуулах, хэрхэн ашиглах, мөн энэ төслийн хүрээнд хамтран ажиллаж буй Австралийн геологийн алба, МУ-ын Ашигт малтмал, газрын тосны газрын мэдээллийг түгээхэд зориуллаа. Mris.mn цахим хаяг бүхий орон зайн хайлт хийх, мета дата каталог системийг фэйсбүүкээр сурталчилсан нь 4400 уншигчид хүрч, 401 хандалт авчээ. Энэ жишгээр нэг сарын хугацаанд нэг сэдвээр мэдээлэл хүргэх нь зорилтот бүлэг АМЕП-ийн үйл ажиллагааг анзаарах, сонирхох, цахим сүлжээгээр хөтөлбөрийн газартай шууд холбогдох боломжийг нээж байна.

Фэйсбүүкээс гадна АМЕП 2 хөтөлбөр Твиттерт @AusMonXtractive данс нээн ажиллуулж байна. Фэйсбүүкт тавьсантай ижил мэдээллийг мөн Твиттер хуудсандаа нийтэлдэг. Хөтөлбөртэй холбоотой мэдээллүүдийн хайлтаар гарч ирэх магадлалыг нэмэгдүүлэх үүднээс жиргээ мэдээнд ордог түгээмэл нэр томъёо, үгсийн урд чагтан тэмдэглэгээ (hashtag) оруулж, тогтмолжууллаа. Жишээ нь #МОНВАЛ, #МонГеоКат, #ТЭЗҮ зэрэг үйл ажиллагаануудаа чагттай оруулснаар эдгээр төслийн хүрээнд хийсэн бүх жиргээ, мэдээ мэдээллийг олон нийт нэг дор үзэх боломжтой юм.

Нүүр тулсан уулзалтууд хийх, зөвлөгөөн зохион байгуулахад тэргүүлэх ач холбогдол өгч, хэрэгжүүлж эхэлснээс гадна АМЕП-ийн мэдээллийн хуудсыг тогтмолжуулж, цахим хуудас нээн, фэйсбүүк, твиттерээр мэдээ мэдээллээ идэвхтэй түгээж эхэлсэн нь АМЕП хөтөлбөрийн нэгдүгээр шатаас хоёрдугаар шатанд гаргасан томоохон ахиц гэж үзэж байна. Дээрх сувгуудын хэрэглэгч, олон нийтийн тавьж буй асуултууд, цахим статистик үзүүлэлтээс харахад харилцааны стратеги үр дүнгээ өгч байна. Цаашид АМЕП 2-ын түгээж буй мэдээлэл хэр ач холбогдолтой байгааг дэлгэрүүлэн судлахаар төлөвлөж байна.

## “Хамтын ажиллагааны талаарх талуудын үзэл бодол, хандлага” судалгаа

Хөтөлбөрийн бүх оролцогч талын дунд “Хамтын ажиллагааны талаарх үзэл бодол, хандлага” цахим судалгааг 2019 оны 10-аас 11 дүгээр сард явууллаа. Энэ нь үр нөлөөтэй хамтран ажиллахад тулгарч буй сорилтуудын талаар оролцогч талуудын санаа бодлыг тандах зорилготой судалгаа байсан. Судалгааны асуулга хүлээн авсан нийт хүн амын 23 хувь нь судалгаанд оролцсон. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь эрдэс баялгийн салбарт үр дүнтэй хамтын ажиллагаа ховор, мөн тус салбарт сүүлийн хоёр жилд ямар нэг дорвитой

өөрчлөлт хийгдээгүй гэжээ. Үр дүнтэй цөөн хөтөлбөрийн жишээнд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага, Монгол улсын эрдэс баялгийн салбарын удирдлагыг бэхжүүлэх төсөл (СЕСМИМ) багтаж байна. Эдгээр нь олон улсын эсвэл хандивлагч байгууллагын санхүүжилт бүхий төсөл, хөтөлбөр байсан нь анхаарал татаж байна. Хэдийгээр төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд өөр өөр зорилго чиглэлтэй ч бүгд санал нэгтэйгээр ард иргэдтэй хамтран ажиллах, оролцоог нь сайжруулах, орон нутгийн иргэд, ТББ-уудыг уул уурхайн салбарын бодлого, үйл ажиллагааны шийдвэр гаргалтад оролцуулах нь хамтын ажиллагааны хамгийн үр дүнтэй арга хэлбэр, боломж гэж хардгаа илэрхийлсэн.

Судалгааны үр дүнгээс мөн төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд хамтын ажиллагаанд өөр өөр өнцгөөс ханддагийг харж болно. Төрийн хувьд уул уурхайн салбарын эдийн засгийн үр ашгийг орон нутагт хүртээх, иргэдэд ойлгуулах сонирхолтой байдаг. Харин хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүд орон нутгийн иргэд уул уурхайн боловсролтой болж, олж авсан мэдлэг мэдээлэл дээрээ үндэслэн уурхайн компанийг дэмждэг байгаасай гэж хүсдэг байна. Иргэний нийгмийн байгууллагууд орон нутагт иргэдийн эрхийг хамгаалж, уурхайн компаниудаар хүний эрхийг хангуулан ажиллахыг зорьдог. Эдгээр ашиг сонирхлыг хэрхэн уялдуулж, амжилттай хамтран ажиллах боломжийг АМЭП 2 хөтөлбөр судална. Судалгааны дэлгэрэнгүй тайланг [атер.mn](http://атер.mn) хөтөлбөрийн цахим хуудсаас үзнэ үү.

# Үйл ажиллагааны хураангуй

АМЕП 2 хөтөлбөрийн сонгон хэрэгжүүлсэн төсөл бүрийн зорилт эрдэс баялгийн салбар дахь оролцогч талуудын хамтын ажиллагаа болон хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах гэсэн АМЕП 2-ын үндсэн зорилготой уялдсан. Энэ бүлэгт төслүүдийн үйл ажиллагааг 1) техникийн туслалцааны ажлуудын явц, 2) хамтран ажиллаж буй байгууллага, институцидээ төсөл хэрэгжүүлэгч хэрхэн тусалж, хувь нэмэр оруулж байгаа гэсэн хоёр чиглэлээр тайлагналаа. Хөтөлбөрийн хүрээнд сонгон хэрэгжүүлж буй бүх төслийн үйл ажиллагааны үр дүнг нэгтгэн, хөтөлбөрийн үндсэн зорилгод ямар бодит хувь нэмэр оруулж буйг хоёрдугаар жилийн тайланд тусгахаар төлөвлөж байна. Учир нь одоо хэрэгжүүлж буй төслүүд бүрэн дууссаны дараа үр дүнг нь үнэлэх боломжтой болох юм.

Хяналт, үнэлгээний төлөвлөгөөнийхөө дагуу АМЕП 2 хөтөлбөр сэтгэл ханамжийн судалгаа явуулж, үзүүлж буй зөвлөх үйлчилгээгээ хамтрагч талуудаар тогтмол үнэлж дүгнүүлж байна. Дийлэнх төсөл хэрэгжилтийн эхний шатандаа явж байгаа тул тавьсан зорилтдоо хүрсэн эсэх талаар дүгнэлт гаргахад арай эрт байна. Явцаас нь харахад төсөл бүр өмнөө тавьсан зорилгодоо хүрэх бүрэн боломжтой гэж үзэж байна (шалгуур үзүүлэлт тус бүрээр үр дүнг нарийвчлан гаргана). Хамтын ажиллагааг дэмжих зорилгын хүрээнд хамааралтай төсөл хөтөлбөр, үйл ажиллагаа бүрт ашиг сонирхол бүхий байгууллагуудын оролцоог хангаж ажиллахыг хичээлээ.

АМЕП 2 хөтөлбөрийг үйлдвэрлэгч хэмээн үзвэл эцсийн бүтээгдэхүүнд техникийн туслалцаа, судалгаа, хэлэлцүүлэг, зөвлөгөөн, үр дүнтэй хамтын ажиллагаа бий болгох зэрэг ажил багтана. АМЕП 2-ын хүрээнд олон улсын нэг зөвлөх Монголд хүрэлцэн ирж, МОНВАЛ кодекс боловсруулах, ТЭЗҮ-тэй холбоотой дүрэм журам шинэчлэх төслүүд дээр ажиллалаа. Зөвлөхийн өгсөн олон улсад баримталдаг ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээтэй холбоотой мэдээ мэдээллийг оролцогч талууд чанартай, цагаа олсон хэмээн үнэлсэн бол түнш агентлагууд дараагийн шатны ажлуудаа төлөвлөх суурь болгон ашиглаж байна. Австралийн татварын албатай эхлүүлж буй хамтын ажиллагааны хүрээнд Монгол байгууллагууд уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн үеийн нягтлан бодох бүртгэлийн талаарх мэдлэг мэдээллээ дээшлүүлэх юм. KPMG аудитын компани нягтлан бодох бүртгэл, санхүүгийн аргачлал боловсруулах ажлыг гүйцэтгэж байна.

АМЕП 2 хөтөлбөрийн баг Австралийн ГХХЯ-тай нягт хамтран ажиллаж, төсөл тус бүр дээр оролцох, хамтран ажиллах, мэдээлэл хүргүүлэх талуудыг тодорхойлсоор ирсэн. Хоёр төсөл дээр олон талын төлөөлөл бүхий ажлын хэсэг байгуулахыг АМЕП 2 дэмжиж ажилласан нь яамдыг бусад агентлагтай, мөн мэргэжлийн холбоодыг төрийн байгууллагауудтай холбосон хамтын ажиллагааны суурь болон өргөжиж байна. Монгол дох уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн үеийн нягтлан бодох бүртгэлийн аргачлал боловсруулах, эсвэл нүүрсний давхаргын метан хийн судалгаа зэрэг төсөлд хувийн хэвшлийг шууд оролцуулах боломж харагдаж байна.

## Төсөл 1. Монгол Улсын ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний кодекс боловсруулах (МОНВАЛ)

➤ Үр дүн: Монгол Улс олон улсын сайн туршлагад нийцсэн ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний кодексыг батлах, хэрэгжүүлэх.

Энэхүү төсөл нь хөтөлбөрийн нэгдүгээр шатанд хийгдсэн ажлын үргэлжлэл мөн. Суурь ажлууд сайн хийгдсэн тул хөрөнгийн үнэлгээний кодекс боловсруулахад хамтран ажиллах байгууллага (Санхүүгийн зохицуулах хороо), мөн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн туршлагыг институцийн түвшинд суулгаж өгөх зорилго нь тодорхой болсон байсан төсөл юм. Төслийн баг бүх ажлаа төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, МОНВАЛ хөрөнгийн үнэлгээний кодексын эхний төслийг хамтарсан ажлын хэсэгт хүлээлгэн өглөө. Ажлын хэсгийн гишүүдийн саналыг авсны дараа кодексыг илүү өргөн хүрээнд түгээх, сургалт явуулах ажлууд хийгдэнэ. АМЕП 2 хөтөлбөр олон улсын төдийгүй салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн, мэдлэг туршлагатай дотоодын зөвлөхүүдийг шалгаруулан, хамтран ажиллаж байна. Ажлын хэсэгт холбогдох яам, мэргэжлийн холбоодын төлөөлөл багтсан. Энэ ажлын хэсгийг хөтөлбөрийн гол түншлэгч байгууллага удирдан, зохион байгуулахаас гадна төслийн үйл ажиллагаа, үр дүнг бүхэлд нь хариуцан ажиллаж байна. Тус хорооны удирдлагын багт гарсан томоохон өөрчлөлтөөс үл хамааран, Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-той хамтран АМЕП 2 хөтөлбөрийн эхлүүлсэн ажил ийнхүү амжилттай хэрэгжиж буй нь төрийн байгууллагын үйл ажиллагааны үргэлжлэл, тасралтгүй бодлогын шилдэг жишээ, талуудын тогтоосон бат бэх харилцааны илэрхийлэл болно.

Төслийн хүрээнд хийгдэх нэг ажил үлдсэн нь “Хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, мэргэжилтнүүдийн МОНВАЛ кодексыг ашиглах чадавхийг бэхжүүлэх сургалт” юм. СЗХ-ны зүгээс МОНВАЛ кодексыг эцэслэн баталсны дараа олон улсын сургагч дээрх сургалтыг хийхээр төлөвлөсөн. Хэрэв кодекс батлагдаж, КОВИД-19 халдвараас шалтгаалан олон улсын аялалд тавьсан хориг үргэлжлэх тохиолдолд

сургалтыг дотоодын зөвлөх багш явуулах боломжтой. Гэхдээ сургалтыг дотоодын багшаар удирдан явуулах эсэх шийдвэрийг АМЕП 2 хөтөлбөрийн баг бус харин СЗХ, ажлын хэсэг гаргана.

МОНВАЛ кодексын ач тус, үр нөлөө уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг олон оролцогч талд шууд мэдрэгдэхгүй. Гэхдээ урт хугацаанд, ирээдүйд энэ кодекс ашиг сонирхлыг нь ямар нэг байдлаар хөндөх байгууллагууд (уурхайн компаниуд, мэргэжлийн холбоод) -тай АМЕП 2 холбоо сүлжээгээ ашиглан хүрч уулзах, мөн олон нийтийн форумыг ашиглан хөрөнгийн үнэлгээг ил тод хийх, урьдчилан таамаглаж болохуйц дүрэм журамтай байхын ач холбогдлыг тайлбарлан таниулах ажлыг хийлээ. Мөн ашигт малтмалын хөрөнгөө үнэлэх сайжруулсан арга аргачлал нь Засгийн газар арилжааны нууц мэдээ мэдээллийг (Жнь: хувийн хайгуулын компанийн илрүүлсэн орд газрын нөөцийг мэдэх гэж Засгийн газар шахалт үзүүлэх) олж авах боломжийг нээнэ гэх мэт буруу ойлголтыг залруулах, эргэлзээг тайлахад анхааран ажиллалаа. Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний кодексийг сонирхож болох бүх бизнес, шинжлэх ухааны байгууллагуудад АМЕП 2 мэдээлэл хүргэж ажиллаж байна. Үүнд компаниуд, ШУТИС-ийн харъяа Геологи, уул уурхайн сургууль, АМЕП 1 хөтөлбөрийн хүрээнд кодексыг санаачлан, анхны хувилбар дээр ажиллаж байсан СЗХ-ны мэргэжилтнүүд багтана. Энэ хүмүүс АМЕП 2-ын чухал оролцогч талууд бөгөөд Монгол Улс өөрийн гэсэн үнэлгээний кодекстой байхын ач холбогдлыг бүрэн ойлгосон мэргэжилтнүүд тулд МОНВАЛ кодексийн эцсийн хувилбарыг боловсруулах болон батлагдахад үнэтэй (constructive) хувь нэмэр оруулах чадвартай.

## Төсөл 2. Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, хүлээн авах журмыг шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх

➤ Үр дүн: ТЭЗҮ-ийн журмыг шинэчлэх, мөрдөж эхлэх; ТЭЗҮ боловсруулах, хүлээн авах, батлах үйл явцыг амар хялбар, шуурхай, тодорхой болгоно.

Техникийн туслалцааны хүрээнд АМЕП 2 Монгол болон олон улсад ТЭЗҮ-ийг хэрхэн боловсруулдаг туршлагыг харьцуулан судалж, шийдвэрлэх шаардлагатай байгаа асуудлуудыг тодорхойллоо. АМЕП 2 хөтөлбөрийн гэрээлж ажилласан олон улсын зөвлөх дээрх асуудлуудыг хөндсөн дэлгэрэнгүй илтгэл тавьж, УУХҮЯ, ажлын хэсэгт орж ажиллах гишүүд, Уул уурхайн зураг төсөл зохиогчдын холбоо, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл зэрэг байгууллагын төлөөллүүдийн асуултад хариулж, зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Олон талын оролцоог хангасан, цаашид энэ асуудлыг манлайлан удирдах боломжтой төлөөллүүдээс бүрдсэн ажлын хэсэг УУХҮЯ байгуулсан хэдий ч КОВИД 19 халдвараас үүдэн, хараахан хуралдаагүй байна. Журмын төслийг шинэчлэн боловсруулах, түүнд шаардлагатай бэлтгэл ажлыг ямар цаг хугацаанд хийхээр төлөвлөж байгаа зэргийг ажлын хэсэг шийднэ. АМЕП 2 хөтөлбөр ТЭЗҮ төслийн үйл ажиллагааг сонирхож буй бүх байгууллагатай нягт хамтран ажиллаж буй бөгөөд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөндөө ч оруулсан байгаа. Гэхдээ төслийн хэрэгжих хугацааг түргэсгэх боломж үгүй юм. 2020 оны 4 дүгээр сард хөтөлбөрийн багийн зүгээс журмын төсөлд хувь нэмэр оруулах асуудлаар семинар зохион байгуулсан.

ТЭЗҮ боловсруулах, батлах зэрэг асуудлыг сонирхон судалдаг төрийн байгууллага, мэргэжлийн холбоод, компани, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулсан дугуй ширээний хэлэлцүүлгийг АМЕП 2 санаачлан зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлэгт оролцогчид энэ төслийг цаашид ажлын хэсэг удирдан авч явах шаардлагатай гэдэг дээр санал нэгджээ. Хэлэлцүүлэг төр болон салбарын мэргэжилтнүүдийг нэг дор цуглуулж, уулзаж ярилцах боломжийг олгосон. Ялангуяа уурхайн зураг төсөл боловсруулагчид ТЭЗҮ-ийн шинэчилсэн журмын төслийг анхааралтай ажиглаж буйгаа илэрхийлээд, ТЭЗҮ-тэй холбоотой олон бүрхэг асуудлыг ажлын хэсэг тодорхой болгож, бодлогын зөрүүнүүдийг арилгана хэмээн найдаж байгаагаа хэлсэн.

ТЭЗҮ-ийн зохицуулалт одоогийн хуулийн тогтолцоонд хэрхэн тусгагдсаныг судалж, Монголын хүчин төгөлдөр зохицуулалт болон олон улсын сайн туршлага хооронд ямар зөрүү, хийдэл байгааг тодорхойллоо. Улмаар хууль тогтоомжийн хийдлийн судалгааны тайлан, зөвлөмжөө УУХҮЯ, ажлын хэсгийн гишүүдэд танилцуулахад бэлэн болгосон.

## Төсөл 3. МУ-ын геологийн мэдээллийн каталог системд мэдээллийг бүрэн оруулах нь

➤ Үр дүн: МонГеоКат систем бүрэн хэмжээнд ажиллаж, тогтмол шинэчлэгдэж, хэрэглэгч, хөрөнгө оруулагчдад цахимаар мета дата хүргэдэг болох.

Энэ төсөл нь АМЕП 1-д хэрэгжүүлсэн ажлын үргэлжлэл бөгөөд МУ бол хөрөнгө оруулагчдад таатай орон гэсэн эерэг дүр төрхийг бүрдүүлж, хөрөнгө оруулагчдад хэрэгтэй багц өгөгдлийг цахимаар хүргэж буй чухал бүтээгдэхүүн үйлчилгээ юм. Төслийг үргэлжлүүлэхдээ цар хүрээг нь өргөтгөж, мета дата болон абстракт

хураангуйг нэмлээ. Төслийн үйл ажиллагаа төлөвлөгөөний дагуу хэрэгжиж, нийт 376 тайлан, мета өгөгдлийг системд оруулсан. Мэдээллийг системд оруулах ажилд АМГТГ тэргүүлэх ач холбогдол өгч ажиллалаа. Ажлын цаг, хүний нөөцийн хязгаарлагдмал байдлаас үүдэн, төслийн хоёр дох бүрэлдэхүүн хэсэг болох цахим хуудас шинэчлэх ажил хойшлогдоод байсан юм. Гэхдээ энэ тайланг бичиж байх хугацаанд АМГТГ АМЕП 2-т хандан, цахим хуудсаа шинэчлэх ажлыг эхлүүлэх санал тавьсныг талархан хүлээн авсан. Тайлант хугацааны төгсгөлд энэ төсөл бүрэн хэрэгжиж дуусна.

## Төсөл 4. Монгол дахь уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн үеийн нягтлан бодох бүртгэлийн аргачлал боловсруулах нь

➤ Үр дүн: Уул уурхайн компаниудын гаргаж буй санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн үндэсний стандартад заасан нөхөн сэргээлт, хаалтын журамд бүрэн нийцсэн байх. (Энэ үр дүндээ хүрч болох ч гүйцэтгэх ажлын цар хүрээнээс хамааран зарим нэг үр дүнгийн үзүүлэлтийг шинэчлэх шаардлагатай байгаа.)

Уул уурхайн салбарын нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нэлээд асуудал байдаг бөгөөд АМЕП 2 эдгээр асуудлыг шийдэх хэд хэдэн төслийн санал хүлээн авсан юм. Төслийн саналуудыг эрэмбэлэх үүднээс Сангийн яамны (СЯ) мэргэжилтнүүдтэй удаа дараа уулзаж, зөвлөлдлөө. Улмаар уул уурхайн салбарт хамаарах нягтлан бодох бүртгэлийн бүх стандартыг хэрэгжүүлэх заавар боловсруулах хүсэлтийг СЯ АМЕП 2-т ирүүлсэн нь хөтөлбөрийн хамрах хүрээ, төсвийн чадамжаас хэтэрсэн тул эдгээрээс хамгийн үр өгөөжтэй, нэг асуудлыг сонгох саналыг АМЕП 2 СЯ-нд тавьсан. Үүний дагуу уул уурхайн компани нөхөн сэргээлт хийх үүргээ биелүүлэх, нөхөн сэргээлтийн сан үүсгэж, хөрөнгө хуваарилах, түүнийгээ нягтлан бодох бүртгэлд тусгах журам боловсруулах ажлыг хоёр тал сонгосон.

АМЕП 2 энэ төслийг сонгохдоо уул уурхайн салбарын хариуцлага, ил тод байдлыг дээшлүүлэх, тус салбарт олон нийтийн итгэл үнэмшлийг нэмэгдүүлэх ач холбогдлыг нь харгалзан үзсэн. Энэ журмыг боловсруулах ажилд дотоодын нягтлан бодох бүртгэлийн компаниудаас сонгон шалгаруулахыг АМЕП 2 зорьсон ч компаниуд стандарт шаардлагад хүрээгүй. Тиймээс олон улсын аудитын KPMG компанийг сонгосон бөгөөд тус компанийн мэргэжилтнүүд СЯ-наас тавьж буй шаардлага, хүлээлтийг бүрэн ойлгохын тулд СЯ-ны мэргэжилтнүүдтэй уулзаж байна. Үүний дараа заасан хугацаанд биелүүлж болохуйц, бодит ажлын төлөвлөгөө гарган ажиллана.

Энэ төсөл нь яамдын ажлын уялдааг сайжруулах, мөн шинээр гарсан заавраа хувийн хэвшилээр мөрдүүлэхэд яамд уул уурхайн компанитай хэрхэн амжилттай хамтарч болох туршилт, жишиг болох юм. Улмаар уул уурхайн компаниудыг санхүүгийн тайландаа тусгасан тоо бүрийнхээ төлөө хариуцлага хүлээдэг болгох зорилготой. Энэ төслийн үйл ажиллагаа хамаатай байж болох яамдад АМЕП 2 мэдээлэл хүргүүлсэн. Одоогоор АМЕП 2-той энэ төсөл дээр хамтран ажиллах санал яамдаас хараахан ирүүлээгүй байна.

## Судалгааны төсөл 1. Нүүрсний давхаргын метан хий (НДМХ) – Австралийн эрх зүйн орчин, зохицуулалт

➤ Нүүрсний давхаргын метан хий ашиглах, үүнтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг хийх шаардлага гарахад хэрэглэж болох суурь судалгааг энэ төслийн хүрээнд хийж байна. Гадаад улсын туршлагыг судалж, харьцуулалт хийсэн энэ баримт бичгийг МУ-ын ирээдүйн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид ашиглаж болно.

Нүүрсний давхаргын метан хийн олборлолт, ашиглалтаараа дэлхийд тэргүүлэгч Австрали улс, тэр дундаа Күйнсланд мужийн туршлагаас суралцах боломжийг энэ төсөл олгоно. Нүүрс болон метан хийн давхцыг компаниуд гэрээ хэлэлцээрээр хэрхэн шийдэж болох хувилбарыг АМЕП 2 дэвшүүлсэн. Мөн шийдвэр гаргах түвшинд нүүрсний давхаргын метан хийн эрх зүйн зохицуулалтыг улсын төсвийн төлөвлөлтөд тусгах замаар хэрхэн шийдэх арга замын тодорхойллоо.

Энэ асуудлаар мэргэшсэн байгууллага нь Күйнсландын их сургуулийн Байгалийн хийн судалгааны төв бөгөөд төслийн хүрээнд хийж гүйцэтгэх ажил, шаардлагатай зүйлсийг тодорхойлох зэрэгт АМЕП 2 Байгалийн хийн төвийн заавар зөвлөгөөг хүлээж байна. Мөн КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор төслийн үйл ажиллагаа удаашраад байна.

Тулгамдаад буй асуудлуудыг сайтар ойлгох үүднээс АМЕП 2 салбарын эрдэмтэн, мэргэжилтнийг оролцуулан, санал солилцлоо. Эдгээр уулзалт хэлэлцүүлгээс олж авсан мэдээ мэдээлэлд үндэслэн, ажлын даалгавар боловсруулсан. Улмаар ажлын даалгаврыг гүйцэтгэх, мөн хийн тусгай зөвшөөрлийн давхцалтай холбоотой асуудлыг харьцуулан судлах салбарын болон хуулийн зөвлөхүүдтэй гэрээ байгуулан, ажиллаж

эхэллээ. Тус ажлыг 2020 онд багтаан дуусгах төлөвлөгөөтэй байна. Күйнсландын их сургуулийн Байгалийн хийн төвийн оролцоотой хийгдэх ажлууд ирэх онд үргэлжилнэ.

КОВИД-19 цар тахал Австралийн их дээд сургууль, Күйнсландын их сургуулийн эрдэмтэн судлаачдын хэвийн үйл ажиллагаанд шууд нөлөөлж буй учир төсөлтэй холбоотой зарим ажлыг цагт нь гүйцэтгэх боломж хязгаарлагдмал байна. Байгалийн хийн төв энэ оны эцсээр ирээдүйд үйл ажиллагаагаа хэрхэн явуулах илүү тодорхой дүр зурагтай болно хэмээн найдаж байгаа бөгөөд төслийн хүрээнд хариуцан авсан ажлаа оны эцэст гүйцэтгэх боломж гарах болов уу гэсэн хүлээлттэй байна. Үйлчилгээ үзүүлэх өөр байгууллагыг АМЕП 2 мөн тодруулсан хэдий ч Күйнсландын их сургуулийн багтай хамтран ажиллах боломж бололцоог үргэлжлүүлэн хайх нь зүйтэй гэж салбарын мэргэжилтнүүд зөвлөсөн.

# Хавсралт 1: Өөрчлөлтийн онол



